

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/124/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020      Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:              Т.Мөнхтогтох

Утас: 70523020      Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ДГА	Дорноговь аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл .....	11
3.1.1	Илрүүлэлт:.....	11
3.1.2	Эрсдэл: .....	11
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	22

## 1 Аудитын гэрчилгээ



44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.02.25 № 1-6/149

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД  
СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Ю.ЧУЛУУНБААТАР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэст танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 31-ээс 2019 оны 02 дугаар сарын 04-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 38а/4-119 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс нь найдвартай, баталгаатай үйлчилгээ, иргэд олон нийтийн итгэл дэмжлэг гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулиар Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 4.0” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 1* хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны Нийт зардал 782,186.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,821.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	480.00	Холбогдох зардлаас зарцуулаагүй.
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	480.00	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

### 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, 2 арга хэмжээнд зориулан 2018 онд 782,186.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 779,357.8 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтэс нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Илрүүлэлт. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

Зардлыг бүлэг хооронд зарцуулах зөвшөөрөлгүйгээр цэвэр бохир усны зардлаас 240.0 мянган төгрөгийг аудитын төлбөрт, тээврийн хэрэгслийн татварын зардлаас 240.0 мянган төгрөгийг хог хаягдлын хураамжийн төлбөрт тус тус шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.3 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” заавартай нийцэхгүй байна.

**Эрсдэл.** Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, үнэн зөв иж бүрэн байх аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байх.

**Өгсөн зөвлөмж.** Хог хаягдлын хураамж, аудитын төлбөр, газрын төлбөр зэрэг зардлуудыг 2020 оны төсвийн төсөлд тусгаж, тус зардлуудыг төсөвт тусгуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

---

- 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>79,552,482.53</u></b>	<b><u>94,648,212.99</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	00.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,422,424.82	584,939.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,422,424.82	417,398.52
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	167,541.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	167,541.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	15,740,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	15,740,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	59,390,057.71	94,063,273.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	33,072,170.65	36,317,255.65
35110	Тусгай зориулалттай материал	32,727,580.65	35,599,065.65
35130	Эм боох материал	344,590.00	718,190.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,942,887.06	53,436,017.82
35410	Бичиг хэргийн материал	2,667,119.00	10,666,228.26
35420	Аж ахуйн материал	7,695,576.40	7,819,922.40
35430	Сэлбэг хэрэгсэл	464,900.00	3,328,400.00
35440	Түлш, шатах тослох материал	3,653,483.66	2,657,796.66
35450	Барилгын засварын материал	00.00	16,133,615.00
35460	Хүнсний материал	2,809,260.00	85,388.00
35470	Бусад хангамжийн материал	4,652,548.00	12,744,667.50
35500	Биологийн хөрөнгө	00.00	00.00
35600	Мал амьтад	4,375,000.00	4,310,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>773,959,549.98</u></b>	<b><u>1,269,833,013.22</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	773,959,549.98	1,269,833,013.22
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	773,913,716.56	1,122,686,179.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	846,902,718.00	958,145,052.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,394,975.04	199,901,875.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-112,057,055.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	138,328,580.60	168,796,645.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,805,695.06	-104,927,824.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,560,937.39	24,865,296.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,200,729.49	-15,630,692.07
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,083,951.00	3,083,951.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,479,004.00	2,995,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,040,340.12	-2,486,068.71
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	45,833.42	147,146,833.46
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-104,166.58	-129,166.54
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	147,126,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>853,512,032.51</u></b>	<b><u>1,364,481,226.21</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	00.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>853,512,032.51</b>	<b>1,364,481,226.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	853,512,032.51	1,364,481,226.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	303,726,981.23	450,852,981.23
51101	Өмч: - төрийн	303,726,981.23	450,852,981.23
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	123,865,750.28	182,222,929.70
51210	Өмнөх үеийн үр дүн	123,865,750.28	123,865,750.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	58,357,179.42
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,919,301.00	731,405,315.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> <b>VI=IV+V</b>	<b>853,512,032.51</b>	<b>1,364,481,226.21</b>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>838,750,288.90</b>	<b>953,275,373.14</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>75,879,688.90</b>	<b>112,921,561.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	75,879,688.90	112,921,561.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,938,611.00	23,708,513.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	16,541,070.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,391,263.00	4,347.31
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,547,348.00	7,163,096.00
120009	Бусад орлого	48,941,077.90	89,213,047.83
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>762,870,600.00</b>	<b>840,353,812.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	736,610,600.00	765,186,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,610,600.00	765,186,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,300,000.00	35,667,612.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,300,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,667,612.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	960,000.00	39,500,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	960,000.00	39,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>850,294,537.78</b>	<b>875,231,783.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>850,294,537.78</b>	<b>875,231,783.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	831,570,309.15	872,862,328.02
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	615,413,276.99	648,962,205.00
210101	Үндсэн цалин	329,362,811.65	608,619,344.00
210102	Нэмэгдэл	286,050,465.34	40,342,861.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,632,278.34	14,335,542.87
210201	Тэтгэврийн даатгал	1,357,296.00	1,138,362.90
210202	Тэтгэмжийн даатгал	179,515.00	142,294.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	160,871.00	113,835.58
210204	Ажилгүйдлийн даатгал	47,410.00	24,042.40
210205	Эрүүл мэндийн даатгал	12,887,186.34	12,917,007.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,148,329.50	51,295,311.09
210301	Гэрэл, цахилгаан	11,333,851.00	10,903,993.81
210302	Түлш, халаалт	9,735,690.95	29,856,018.08
210303	Цэвэр, бохир ус	6,432,179.55	7,366,899.20
210304	Байрны түрээс	3,646,608.00	3,168,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	51,257,272.02	46,350,734.02
210401	Бичиг хэрэг	7,007,375.50	4,831,187.52
210402	Тээвэр, шатахуун	32,555,990.00	36,697,387.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,730,378.02	3,675,129.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,449,688.50	1,147,030.00
210408	Бараа материал ақталсны зардал	6,513,840.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,343,957.00	17,246,544.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	354,405.00	76,400.00
210502	Хоол, хүнс	16,989,552.00	16,872,094.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	298,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,442,281.00	18,896,127.50
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	58,000.00	00.00
210604	Урсгал засвар	27,384,281.00	18,896,127.50
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,680,410.00	6,444,960.00
210702	Дотоод албан томилолт	7,680,410.00	6,444,960.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	852,796.00	450,000.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	303,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	430,384.00	450,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	119,412.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,799,708.30</b>	<b>68,880,903.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	267,588.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,600.00	375,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,476,520.30	68,505,903.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,724,228.63</b>	<b>2,369,455.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,500,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,500,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,224,228.63</b>	<b>2,369,455.37</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,224,228.63	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,369,455.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-11,544,248.88</b>	<b>78,043,589.75</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,315,680.98</b>	<b>2,108,333.10</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	6,315,680.98	2,108,333.10
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,645,327.39</b>	<b>21,794,743.43</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,645,327.39	5,403,013.32
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	16,391,730.11
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-2,329,646.41</b>	<b>-19,686,410.33</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-13,873,895.29</b>	<b>58,357,179.42</b>

**АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>776,337,863.00</b>	<b>817,394,882.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>14,427,263.00</b>	<b>16,541,070.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,427,263.00	16,541,070.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	14,427,263.00	16,541,070.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	16,541,070.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,427,263.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>761,910,600.00</b>	<b>800,853,812.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	736,610,600.00	765,186,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	736,610,600.00	765,186,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	25,300,000.00	35,667,612.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,300,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,667,612.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>770,981,513.00</b>	<b>807,453,757.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>770,981,513.00</b>	<b>807,453,757.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>752,257,284.37</b>	<b>805,084,301.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	621,484,658.65	647,265,356.82
210101	Үндсэн цалин	505,159,599.65	404,907,588.00
210102	Нэмэгдэл	116,025,059.00	242,357,768.82
210104	Урамшуулал	300,000.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,595,762.20	12,178,558.44
210201	Тэтгэврийн даатгал	6,299,343.00	2,162,702.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,296,419.20	10,015,856.44
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,657,971.50	43,334,311.09
210301	Гэрэл, цахилгаан	13,133,851.00	9,103,993.81
210302	Түлш, халаалт	10,971,090.95	24,653,018.08
210303	Цэвэр, бохир ус	6,432,179.55	6,408,899.20
210304	Байрны түрээс	3,120,850.00	3,168,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,207,748.02	44,866,678.28
210401	Бичиг хэрэг	3,782,800.00	5,033,076.78
210402	Тээвэр, шатахуун	31,695,600.00	32,223,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,935,378.02	3,984,129.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,793,970.00	3,625,672.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,239,850.00	15,410,822.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	149,700.00	450,000.00
210502	Хоол, хүнс	14,755,150.00	13,960,822.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	335,000.00	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,657,500.00	34,283,615.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	20,857,500.00	33,283,615.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,680,410.00	6,444,960.00
210702	Дотоод албан томилолт	7,680,410.00	6,444,960.00

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	733,384.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	223,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	430,384.00	450,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	850,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	850,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,724,228.63</b>	<b>2,369,455.37</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,500,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,500,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5,224,228.63	2,369,455.37
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,224,228.63	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,369,455.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>5,356,350.00</u></b>	<b><u>9,941,125.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,356,350.00</b>	<b>9,941,125.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,356,350.00</b>	<b>9,941,125.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,356,350.00	9,941,125.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,356,350.00	9,941,125.00
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-5,356,350.00</u></b>	<b><u>-9,941,125.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	303,726,981.23	425,919,301.00	136,987,466.27	866,633,748.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	752,179.30	752,179.30
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>303,726,981.23</b>	<b>425,919,301.00</b>	<b>137,739,645.57</b>	867,385,927.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,873,895.29	-13,873,895.29
C08	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>303,726,981.23</b>	<b>425,919,301.00</b>	<b>123,865,750.28</b>	853,512,032.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>303,726,981.23</b>	<b>425,919,301.00</b>	<b>123,865,750.28</b>	853,512,032.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	305,486,014.28	00.00	305,486,014.28
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	147,126,000.00	00.00	58,357,179.42	205,483,179.42
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>450,852,981.23</b>	<b>731,405,315.28</b>	<b>182,222,929.70</b>	1,364,481,226.21

**АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>782,186,200.00</b>	<b>779,357,814.63</b>	<b>2,828,385.37</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	782,186,200.00	779,357,814.63	2,828,385.37
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	782,186,200.00	779,357,814.63	2,828,385.37
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	647,282,800.00	647,265,356.82	17,443.18
210101	Үндсэн цалин	391,091,200.00	404,907,588.00	-
210102	Нэмэгдэл	256,191,600.00	242,357,768.82	13,833,831.18
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,530,900.00	12,178,558.44	1,352,341.56
210201	Тэтгэврийн даатгал	1,111,700.00	2,162,702.00	-1,051,002.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,419,200.00	10,015,856.44	2,403,343.56
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,713,100.00	40,165,911.09	547,188.91
210301	Гэрэл, цахилгаан	9,129,500.00	9,103,993.81	25,506.19
210302	Түлш, халаалт	25,174,700.00	24,653,018.08	521,681.92
210303	Цэвэр, бохир ус	6,408,900.00	6,408,899.20	0.80
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,748,800.00	41,591,006.28	157,793.72
210401	Бичиг хэрэг	5,588,000.00	5,583,076.78	4,923.22
210402	Тээвэр, шатахуун	30,223,800.00	30,223,800.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,137,000.00	3,984,129.50	152,870.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00	0.00
2105	<b>Нормативт зардал</b>	14,225,000.00	13,579,222.00	645,778.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450,000.00	450,000.00	0.00
210502	Хоол, хүнс	12,775,000.00	12,129,222.00	645,778.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	0.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,832,800.00	16,832,800.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	15,832,800.00	15,832,800.00	0.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	6,472,800.00	6,444,960.00	27,840.00
210702	Дотоод албан томилолт	6,472,800.00	6,444,960.00	27,840.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	530,000.00	450,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	450,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	00.00	80,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	850,000.00	850,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	850,000.00	850,000.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>797,937,450.00</b>	<b>779,357,814.63</b>	<b>18,579,635.37</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	765,186,200.00	762,816,744.63	2,369,455.37

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн 2018 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131001	Улсын төсвөөс санхүүжих	765,186,200.00	762,816,744.63	2,369,455.37
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	32,751,250.00	16,541,070.00	16,210,180.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,000,000.00	16,541,070.00	458,930.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,751,250.00	00.00	15,751,250.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	0.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	0.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	58.00	00.00	58.00
620001	Удирдах ажилтан	01.00	00.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	00.00	55.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	00.00	2.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	00.00	00.00	0.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	00.00	00.00	0.00

**АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31 өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>35,667,612.00</b>	<b>-35,667,612.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	00.00	35,667,612.00	-35,667,612.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	35,667,612.00	-35,667,612.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	3,168,400.00	-3,168,400.00
210304	Байрны түрээс	00.00	3,168,400.00	-3,168,400.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	5,592,802.00	-5,592,802.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	2,000,000.00	-2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	3,592,802.00	-3,592,802.00
2105	<b>Нормативт зардал</b>	00.00	1,831,600.00	-1,831,600.00
210502	Хоол, хүнс	00.00	1,831,600.00	-1,831,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	25,074,810.00	-25,074,810.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,926,510.00	-1,926,510.00
210602	Тавилга	00.00	1,615,000.00	-1,615,000.00
210604	Урсгал засвар	00.00	21,533,300.00	-21,533,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>00.00</b>	<b>35,667,612.00</b>	<b>(35,667,612.00)</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	35,667,612.00	(35,667,612.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00	(20,000,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	15,667,612.00	(15,667,612.00)
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	0.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	0.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	58.00	00.00	58.00
620001	Удирдах ажилтан	01.00	00.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	00.00	55.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	00.00	2.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	00.00	00.00	0.00
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГЭСЭДИЙН ТОО</b>	00.00	00.00	0.00